



**МОНГОЛБАНКНААС МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛЧДИЙН ДУНД
ЗОХИОН БАЙГУУЛДАГ “ШИЛДЭГ ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТЛЭЛ
УРАЛДААНЫ УДИРДАМЖ (2017 оны IV улирал)**

НЭГ. ЗОРИЛГО

Монголбанк эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчдийн ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор эдийн засгийн нийтлэлийн уралдааныг улирал бүр зохион байгуулж байна. Эдийн засаг, мөнгөний бодлогын талаар өндөр түвшинд бичиж, энгийн ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд түгээх мэдлэг чадвартай сэтгүүлчдийн тоо нэмэгдсэнээр энэхүү сэдвээр үнэн бодит мэдээлэл нийгэмд хүрэх боломж нэмэгдэнэ.

ХОЁР.СЭДЭВ: МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ НЬ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн нэгдүгээр заалт болох Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд “Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгоно” гэсэн зорилт орсон байгаа. Ер нь сүүлийн жилүүдэд олон нийттэй харилцах арга хэлбэрийг нэг төрлийн мөнгөний бодлогын хэрэгсэл болгон ашиглаж байна. Мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд түгээж, ойлгомжтой байдлаар тайлбарлах нь орчин үеийн Төв банкны мөнгөний бодлогын салшгүй нэг хэсэг болсон. Учир нь инфляцийн хүлээлт тогтворжиж, мөнгөний бодлогын төлөвийн талаарх тодорхой хүлээлт бүрэлдэн бий болсноор санхүүгийн зах зээл дээрх мөнгөний бодлоготой холбоотой тодорхой бус байдал буурдаг байна. Гэхдээ олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлэхийн тулд багагүй цаг хугацаа, тууштай бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь зөвхөн төв банкны хүчин чармайлтаас гадна нийт зах зээлд оролцогчдын эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг, эрсдэлийн удирдлага, бизнес төлөвлөлт, алсын хараа зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. *Тиймээс мөнгөний бодлогыг олон нийтэд хэрхэн энгийн ойлгомжтой байдлаар хүргэх талаарх судалгаа, бодит жишээ хослуулсан бүтээлийг дараах шалгуурт нийцүүлэн бичиж оролцохыг урьж байна.*

ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

✓ **Шагнал:**

I байр: 500,000 төгрөг + Өргөмжөл

II байр: 400,000 төгрөг + Өргөмжөл

III байр: 300,000 төгрөг + Өргөмжөл

✓ **Материал хүлээн авах хугацаа:** 2017.12.08 (Баасан) 18.00 цаг хүртэл essay@mongolbank.mn хаягаар хүлээн авна (Subject мөрөнд Сэтгүүлчийн нэр, Ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллага,).

✓ **Тэмцээний үр дүнг зарлах хугацаа:** 2017.11.14 (Мягмар)

✓ Шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ

ДӨРӨВ. НИЙТЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

ГУРАВ. ШАЛГАРУУЛАЛТ

✓ **Шагнал:**

I байр: 500,000 төгрөг + Өргөмжөл

II байр: 400,000 төгрөг + Өргөмжөл

III байр: 300,000 төгрөг + Өргөмжөл

✓ **Материал хүлээн авах хугацаа:** 2017.12.08 (Баасан) 18.00 цаг хүртэл essay@mongolbank.mn хаягаар хүлээн авна (Subject мөрөнд Сэтгүүлчийн нэр, Ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллага,).

✓ **Тэмцээний үр дүнг зарлах хугацаа:** 2017.12.15 (Баасан)

✓ Шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, сошиал сувгуудаар олон нийтэд түгээнэ

ДӨРӨВ. НИЙТЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Нийтлэлийг 800-1000 үгэнд багтаан бичих;
- ✓ Судалгаа, тоо баримттай байх;
- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Нийтлэл бичих ерөнхий бүтцийг баримталсан байх;
- ✓ Бусдын бүтээлийг хуулбарлаагүй байх;
- ✓ Нийтлэлийн бичгийн стандарт:
 - Үсгийн фонд: Times New Roman;
 - Үсгийн хэмжээ: 12;
 - Мөр хоорондын зай: 1,5;
 - Margins: top 2 cm, bottom 2 cm, left 3 cm, right 1.5 cm.
- ✓ Нүүр хуудсанд өөрийн овог нэр, ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын нэр, холбоо барих 2 утас, и-мэйл хаягыг бичих.

ТАВ. НИЙТЛЭЛИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР

- ✓ Нийтлэлийг дараах шалгуураар дүгнэнэ:

	Оноо
Ерөнхий шаардлага	
<i>Цаг баримтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/</i>	10
<i>Үгийн тоо /800-1000 үг/</i>	5
<i>Бичгийн стандарт /Фонт, үсгийн хэмжээ, маржин.../</i>	5
Асуултад хариулсан байдал	
<i>Мөнгөний бодлогыг олон нийтэд түгээх арга барилыг тайлбарласан байдал</i>	10
<i>Мөнгөний бодлогыг олон нийтэд түгээх арга барилын ач холбогдлыг тайлбарласан байдал (Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл)</i>	10
Эссений чанар	
<i>Үг үсгийн алдаа</i>	5
<i>Найруулга зүй</i>	5
<i>Логик дэс дараалал</i>	10
<i>Судалгаа/Тоо баримт ашигласан байдал</i>	10
<i>Энгийн ойлгомжтой байдал</i>	10
<i>Унишихад сонирхолтой байдал</i>	10

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр
Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв
МОНГОЛБАНК**

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn веб хуудаснаас
болон (976) 11-310119 утсаар лавлана уу.